



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

### 2019 оныг “Салбарын хүний нөөцийг чадавхжуулах жил” болгон зарлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “2019 оныг Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай 23 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын “2019 оныг Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарлах тухай 2019 оны А/01 дүгээр захирамж, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн салбарын хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн ур чадвар, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор тус газраас 2019 оныг “Салбарын хүний нөөцийг чадавхжуулах жил” болгон зарласугай.

2. “Салбарын хүний нөөцийг чадавхжуулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, батлуулахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.

3. “Салбарын хүний нөөцийг чадавхжуулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, ажлын явц, үр дүнг тайлагнаж ажиллахыг захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т, үйл ажиллагааг олон нийтэд мэдээлж, сурталчлан ажиллахыг мэдээлэл, сурталчилгааны хэлтэс /Д.Жавхлан/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТСҮХ